*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# АРВАЙХЭЭР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ НОГООН БАЙГУУЛАМЖ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЗАЯАДАВАА ОВОГТОЙ ОЮУНСҮРЭНГИЙН ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин: Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлж, усалгаа арчилгааг тогтмолжуулан, хотын өнгө үзэмжийг сайжруулах зорилтын хүрээнд | | | | | | | |
| 1.1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гарагийг “Мод тарих үндэсний өдөр” болгон зарласантай холбогдуулан нийтээр мод тарих ажлыг өрнүүлэх. | Үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, зарж борлуулсан тарьц суулгацын тоогоор | - | 2удаа | Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд мод бутны тарьц суулгацын үзэсгэлэн худалдааг жил бүрийн хавар болон намрын улиралд “Аюуш” баатрын талбайд зохион байгуулж хэвшсэн ба тус үзэсгэлэн худалдаанд үхрийн нүд, чацаргана, монос, гүйлс, бөөрөлзгөнө, улаалзгана, интоор, чавга зэрэг жимсний мод, голт бор, далан хальс, агч зэрэг гоёлын мод,бургас, улиас, хайлаас, шар хуайс зэрэг навчит мод нийт 20 гаруй нэр төрлийн 2-5 настай 250,000 гаруй тарьц суулгацыг худалдан борлуулахаар Бат-Өлзий сумын ”Сум дундын ойн анги”, Хужирт сумын “Өгөөмөр Шунхлай” хязгаарлагдмал хариуцлагатай компани, Хархорин сумын “Баялаг нахиа” хязгаарлагдмал хариуцлагатай компани, Арвайхээр сумын “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГазар, “Бат цэцэрлэгжилт” хязгаарлагдмал хариуцлагатай компани, Тансаг цэцгийн дэлгүүр, Сэлэнгэ | 2025.05 2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аймгийн Шаамар сумын иргэн Н.Амартүвшин нар оролцон давхардсан тоогоор 15 нэр төрлийн 20-30 мянга орчим тарьц суулгацыг айл өрх, албан байгууллагуудад худалдан борлуулсан байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | | |
| 1.2 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд жилийн ажлын төлөвлөгөөг гаргаж, тарих талбайн байршил, зураглалыг газар зохион байгуулалтын урьд оны төлөвлөгөөнд тусган батлуулах | Тарьж ургуулсан мод бутны тоогоор | 95 га | 113га | Тэрбум мод үндэсний хөтөлбөр 2025 оны хаврын мод тарих өдрийн хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгж 9840, айл өрх 2690, нийтийн эзэмшлийн зам талбайд 77500 ширхэг мод тарьсан. Намрын мод тарих өдрийн хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгж 9470, айл өрх 3100 нийтийн эзэмшлийн зам талбайд 57500 мод тарьсан. Мөн шинээр Дайргын голд 5 га, Зэвсэгт хүчний 256 анги 1,5 га, Ус цаг уур орчин шинжилгээний газар 3,2 га хотын ногоон байгууламжийн нэмэгдүүлж хаврын болон намрын мод тарилтаар хотын ногоон байгууламж 121 га боллоо.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.04<br>2025.10 | 100 |
| 1.3 | Арвайн хүрээ" цэцэрлэгт хүрээлэнд мод бут ажлыг зохион байгуулах. | Тарьж ургуулсан мод бутны тоогоор | 300 ширхэг | 500ширхэг | Сумын орон нутгийн төсвийн 60,000,000 төгрөгийн санхүүжилтээр энэхүү ажлын эхлэлийг тавьж Дэлгэрэхийн 3 дугаар багт 1,2 га газрыг хашиж хамгаалсан тус цэцэрлэгт хүрээлэнд хаврын бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд төрийн албан хаагч нараар мод тарих, модны нүх ухах ажлыг зохион байгуулж ажилласан. Тус өдрийн хүрээнд аймгийн мал эмнэлэгийн албан хаагч нар 500 ширхэг хайлсыг тарьж ургуулаад байна. Амьдралт 90 хувьтай байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.05<br>2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Өлзийтийн 4 дүгээр багт 4га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хамгаалалтын зурвас байгуулж мод бут тарих. | Тарьж ургуулсан мод бутны тоогоор | 3000 ширхэг | 5000 ширхэг | Энэ онд Арвайхээр сумын Өлзийтийн 4 дүгээр багт 4га газрыг хашиж хамгаалсан.Нийт 5-н төрлийн 4470 ширхэг мод бутыг шинээр тарьж, нөхөн тарилтаар 2 төрлийн 850 ширхэг мод бут тарьж хавар, намрын нийт тарилтаар 5320 ширхэг модыг тарьж ургуулаад байна. Усалгаа арчилгааг "Арвайхээр цэцэрлэгжилт" ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж байна. Амьдралт 89 хувьтай байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.05<br>2025.10 | 100 |
| 1.5 | Дайргын голд ойн урвас байгуулах. | Тарьж ургуулсан мод, бутны тоогоор | 1500 ширхэг | 2000 ширхэг | Арвайхээр сумын 12 дугаар багт Дайргын голд 2 га газрыг хашиж хамгаалсан. Нийт 5 төрлийн 2100 ширхэг мод бутыг тарьж ойн зурвасыг байгуулан ажиллаж байна. Амьдралт 89 хувьтай байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.05<br>2025.10 | 100 |
| 1.6 | Согоотын 1 дүгээр багийг жишиг ногоон байгууламжтай баг болгох. | Мод, бут тарьсан өрхийн тоогоор | 250 | 300 ширхэг | Арвайхээр сумын Согоотын 1 дүгээр багийг жишиг ногоон байгууламжтай баг болгох зорилгоор Аюулгүй тойргын ногоон талбайд 158 ширхэг хайлаас тарьж ургуулсан. Мөн хашаагаа "Гэр хорооллын стандарт"-ын дагуу тохижуулж, мод бут тарьж ногоон орчин бий болгох сонирхолтой ая тухтай амьдрах орчин бүрдүүлсэн жишиг тохижилттой айл өрхүүдтэй хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан."Арвайхээр цэцэрлэгжилт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас 200 ширхэг хайлаас 40 айл өрхүүдэд өгч тариулсан. Амьдралт 85 хувьтай байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.05<br>2025.10 | 100 |
| 1.7 | Их монгол, Баяннамсрай зэрэг цэцэрлэгт хүрээлэнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх . | Тарьж ургуулсан мод бутны тоогоор | 2000шрхэг | 4000 ширхэг | Энэ онд хавар болон намрын мод тарилтаар "Баяннамсрай" цэцэрлэгт хүрээлэнд шинээр нийт 2353 ширхэг хайлаас, гүйлс, улиас, шар хуайс зэрэг гоёлын болон навчит мод "Их Монгол" цэцэрлэгт хүрээлэнд Банкуудын холбооны нэрэмжит төгөл байгуулахаар 1,5 га талбайд шинээр 5550 ширхэг монос, далан хайльс, гүйлс, голт бор, гацуур, хайлаас зэрэг гоёлын болон навчит мод цэцэрлэгт хүрээлэнд | 2025.05<br>2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6070 мод бутыг шинээр болон мод тарилтаар тарьж байна. Усалгаа арчилгааг тогтмол хийж "Арвайхээр цэцэрлэгжилт" ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж байна. Амьдралт 89 хувьтай байна.2025 онд Их монгол, Баян намсрай цэцэрлэгт хүрээлэнгүүдэд орон нутгийн төсвөөр тог татаж усалгааны асуудлыг 100 хувь шийдсэн. Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | | |
| 1.8 | Байгууллага бүр албан хаагчдынхаа тоогоор мод тарья" аян өрнүүлэх, гадна талбайдаа мод бут тарих боломжгүй байгууллага аж ахуй нэгжээс "Ногоон байгууламжийн журам"-ын дагуу санхүүжилт төвлөрүүлэх | Тарьсан модны тоо | 7000ширхэг | 8000ширхэг | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хавар болон намрын мод тарилтаар Баяннамсрай цэцэрлэгт хүрээлэнд төрийн болон хувийн хэвшлийн 41 байгууллагын төрийн албан хаагчид оролцож 2353, Залуус цэцэрлэгт хүрээлэнд нийт 20 ААНэгжийн төрийн албан хаагчид 1068 модны нүхийг ухаж бэлтгэн тарьц суулгацыг 7 ААН, тарьц суулгацын үнийг 48 ААНэгж 8.609.500 мянган төгрөгийг ногоон байгууламжийн сангийн журмын дагуу тусгай дансанд төвлөрүүлсэн байна. Мод бутны тарилт болон усалгаа арчилгааг "Арвайхээр цэцэрлэгжилт" ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж байна. Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.05 2025.10 | 100 |
| | | Төвлөрүүлсэн мөнгөн дүнгээр | 800,000 төгрөг | 1000,000 төгрөг | | | |
| 1.9 | Нийтийн эзэмшлийн зам талбайд мод бут, зүлэг, цэцэг тарих ажлыг зохион байгуулах | Нэмэгдсэн талбайн хэмжээгээр | 1.5 га | 2га | Мөн шинээр Дайргын голд 5 га, Зэвсэгт хүчний 256 анги 1,5 га, Ус цаг уур орчин шинжилгээний газар 3,2 га хотын ногоон байгууламжийн хэмжээ өмнөх оноос 9,7 га-р нэмэгдүүлж хаврын болон намрын мод тарилтаар хотын ногоон байгууламж 121 га боллоо.Нийтийн эзэмшлийн зам талбайд хавар болон намрын тарилтаар 5 обьектод 135000 ширхэг мод бут таригдсан бөгөөд усалгаа арчилгааг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж амьдралт 87 хувьтай байна. Мөн нийтийн эзэмшлийн зам талбайн 1024$м^2$ талбайд цэцгийн мандал байгуулж, зүлэгжүүлэлт 744 $м^2$ талбайд хийгдсэн. Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.05 2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллах | Нэмэгдсэн талбайн хэмжээгээр | Нийтийн эзэмшлийн зам талбайд 39448 ширхэг, нийт 70424 ширхэг мод бут | Мод үржүүлгийн газарт хийгдэх ажлын төлөвлөгөө төсөл боловсруулагдсан байна | Арвайхээр суманд байнгын үйл ажиллагаа явуулж буй "Арвайхээр цэцэрлэгжилт" ОНӨААТҮГазар мод үржүүлгийн газрын ил талбайдаа 4 настай улиас 1050, 1 настай хайлаас 3900, 2 настай хайлаас 1350, 3 настай хайлаас 14050, 2 настай шар хуайс 30, 5 настай шар хуайс 2530, 2 настай гүйлс 1332, 3 настай бургас 530 гэх мэт 1-5 настай 5 төрлийн 24772 тарьц суулгацын нөөцтэй байна. Монгол Солонгосын хамтарсан "Ногоон хэрэм" төслийн мод үржүүлгийн 2,1 га ил талбайд улиас 39000, мөнгөлөг улиас 241, бургас 27000, хайлаас 355400, Сибирь гүйлс 1661 ширхэг, хүлэмжид Сибирь гүйлс 204, шинэс 546, нарс 548, Монгол бүйлс 1599, жигд 2218, голт бор 5890, хайлаас 15279, шар хуайс 5536 гэсэн 2 настай 11 төрлийн 455122 тарьц суулгацын нөөцтэй байна. Мөн хувиараа мод үржүүлэгтэй иргэн Очирсүрэн мод үржүүлгийн 8 га талбайдаа 1 настай агч 30000, хайлаас 450000, гүйлс 10000, шар хуайс 30000, 2 настай улиас 10000, бургас 20000, хайлаас 400000, 3 настай шар хуайс 8000, хайлаас 200000 нийт 1-3 настай 1,158,000 суулгацын нөөцтэй байна. 2024 оны намрын тооллогоор байнгын үйл ажиллагаа явуулж буй 3 мод үржүүлгийн газрын нийт 1,637,894 ширхэг 1-5 настай, 10 гаруй нэр төрлийн тарьц суулгацын нөөцтэй байна. Дээрх мод үржүүлгийн газруудын эрчим хүч, газрын эзэмшил өмчлөлийн асуудлуудыг шийдвэрлэж, бодлогоор дэмжин ажиллаж байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.04<br>2025.09 | 100 |
| ХОЁР. "Аж ахуй нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ногоон өрх, ногоон гудамж бий болгон, сургалт мэдээллийн ажлыг тогтмолжуулах" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 2.1 | "Айл бүр ам бүлийнхээ тоогоор мод тарья" аян өрнүүлэх, хашаандаа тарих боломжгүй айл өрхөөс "Ногоон байгууламжийн | Тарьсан модны тоо, мод бутны амьдралтын хувь | - | Хашаа төлөвлөлтийн талаар талбайн болон онлайн сургалтуудыг | Айл бүр ам бүлийнхээ тоогоор мод тарья" аяны хүрээнд 2025 оны хаврын мод тарилтаар албан байгууллага, аж ахуйн нэгж 9840, айл өрх 2690, нийтийн эзэмшлийн зам талбайд 77500 ширхэг мод тарьсан. Намрын мод тарих өдрийн хүрээнд | 2025.04<br>2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журам"-ын дагуу санхүүжилт төвлөрүүлэх | Төвлөрүүлсэн мөнгөн дүнгээр | | хийсэн байна | албан байгууллага, аж ахуйн нэгж 9470, айл өрх 3100 нийтийн эзэмшлийн зам талбайд 57900 мод нийт хавар болон намрын мод тарилтаар нийт 160100 мод бутыг тарьж ургуулаад байна.Үүнээс 1080 айл өрх хашаандаа 5790 ширхэг мод бутыг тарьж ургуулж байна."Арвайхээр цэцэрлэгжилт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хайлаас 1500 ширхэг, "Ховд сафари" хязгаарлагдмал хариуцлагатай компани нийгмийн хариуцлагын хүрээнд 1500 ширхэг мод нийт 3000 ширхэг суулгацыг мод тарих орчин нөхцөлөө бүрдүүлж нүхээ ухсан Арвайхээр сумын 13 багийн гэр хорооллын айл өрхүүдэд дэмжлэг үзүүлж нэг багийн 50-аас доошгүй айл өрхөд улиас, хайлаас, агч 3 төрлийн мод олгож тариулсан.Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй "ХАШААНДАА ТАВАН МОД" хөтөлбөрийн хүрээнд "Марзат Арвай" хязгаарлагдмал хариуцлагатай компани, "Хөх дэлхий хөгжил хамгаалал" төрийн бус байгууллагаас Арвайхээр сумын 13, 7, 8, 3 – р багийн 160 өрхөд үрэл, голт бор, гүйлс зэрэг жимсний болон гоёл чимэглэлийн 800 ширхэг мод бутны дэмжлэг үзүүлж, айл өрхүүд хашаандаа тарьж ургуулж нийт 1080 айл өрх 5790 ширхэг мод бутыг тарьж ургуулан хашаа хороогоо тохижуулж амьдралт 87 хувьтай байна. Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | | |
| 2.2 | Байгууллага аж ахуй нэгжүүдийн тохижилт ногоон байгууламжийн ажлын явцад хяналт тавьж, гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол ханган ажиллах | Тохижилт хийж, мод бут тарьсан байгууллагын тоогоор | | Аж ахуй нэгж байгууллагуудын гадна талбайн тохижилт сайжирсан байна. | Өөрийн эзэмшлийн газартай 61 байгууллагатай тохижилтын гэрээ байгуулж, зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан бөгөөд тус байгууллага аж ахуй нэгжүүд гадна талбайдаа шинээр 8854, нөхөн тарилтаар 1206 нийт 9760 ширхэг гүйлс, голт бор, хайлаас, улиас, гацуур, шар хуайс зэрэг 8-10 нэр төрлийн навчит, гоёлын, жимсний мод бут тарьж, 144м$^2$ талбайд зүлэгжүүлэлт хийж, 320м$^2$ талбайд мандлын цэцэг тарьж ургуулан усалгаа арчилгааг | 2025.04<br>2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өөрсдийн хүчээр хийж байна.<br>Мөн байгууллага аж ахуй нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг сайжруулах зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбайд ногоон байгууламж бий болгох ажилд хавар, намрын улиралд 2 удаа албан хаагч бүр 3 мод тарих, нүх ухах ажлыг зохион байгуулж хэвшсэн. 2025 онд “Баяннамсрай” цэцэрлэгт хүрээлэнд 41 төрийн байгууллагын 720 ажилтан, албан хаагч, 2353 мод, бут, Залуус цэцэрлэгт хүрээлэнд 20 төрийн байгууллагын 234 ажилтан албан хаагчид 1068 мод, бутны нүхийг ухаж бэлтгэсэн. Үүний зэрэгцээ мэргэжлийн байгууллагуудын мод үржүүлгийн газраас тарьц суулгацыг худалдан авч нийлүүлэн “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГазар тарилтыг хийж гүйцэтгэсэн ба намрын тооллогоор амьдралт 90хувьтай байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн -100хувь | | |
| 2.3 | Хэсгийн ахлагч нарыг чадавхижуулах, цуврал сургалтуудыг зохион байгуулах, цахим орчинд мэдээлэл нийтлэн иргэдийн мод тарих оролцоог нэмэгдүүлж ажиллах. | Хийсэн сургалтын тоогоор | 2 | 4 | Хэсгийн ахлагч нарыг чадавхижуулах зорилгоор хаврын мод бутны үзэсгэлэн худалдааны үеэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран мод тарих зөвлөмж, гарын авлага бэлтгэн 230 гаруй иргэдэд тарааж хүргэсэн. Мөн 61 байгууллагатай тохижилтын гэрээ байгуулж, мод бутны таналт тайралт, усалгаа арчилгаа, мод бут тарих аргачлал сэдэвт сургалтыг зохион байгуулж хамтарч ажилласан. Мөн хашаагаа “Гэр хорооллын стандарт”-ын дагуу тохижуулж, мод бут тарьж ногоон орчин бий болгосон иргэдэд хэсгийн ахлагчтай нартай зөвөлгөө өгч хамтран ажилласан.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн -100хувь | 2025.04<br>2025.10 | 100 |
| 2.4 | Өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгох экокурс аялал зохион байгуулах. | Үйл ажиллагааны тоогоор | 3 | 6 | Өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгох зорилгоор 2025 онд “Мод тарихын ач тус “Мод тарих аргачлал сэдэвт 8 удаагийн сургалтыг Өвөрхангай аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж ажилласан.Үүнд: | 2025.06<br>2025.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Зэвсэгт хүчний 256-р ангийн 115 алба хаагч<br>• Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын 76 алба хаагч<br>• Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын 54 албан хаагч<br>• Өвөрхангай аймгийн Цагдаагийн газрын 98 албан хаагч<br>• Өвөрхангай аймгийн Ус цаг уур орчин шинжилгээний газрын 34 албан хаагч<br>• Арвай хээр сумын ерөнхий боловсролын нэг дүгээр сургуулийн 78 багш, ажилчид<br>• Тэмүүлэл-Эрдэм сургуулийн 63 багш, ажилчдад танхимын сургалтыг зохион байгууллаа.<br>2025 онд танхимын сургалт 7, практик сургалт 1 нийт 8 удаагын сургалтанд 455 төрийн албан хаагчид, 80 сурагч хамрагдлаа.<br>Мөн Монгол Солонгосын хамтарсан “Ногоон хэрэм” төслийн менежертэй хамтран эко аялал,мод тарих арга технологи сэдэвт практик сургалтыг “Тэмүүлэл – Эрдэм” сургуулийн ахлах ангийн 80 сурагчдад зааж зохион байгуулж ажилласан. | | |
| ГУРАВ. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 3.1 | Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах | -Үүрэг даалгаврын биелэлтээр | | Өдөр тутмын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилгыг чанд мөрдөж ажилласан байна.<br>- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай | Ажлын цаг ашиглалттай холбоотой зөрчил гомдол гаргаагүй. ЗДТГазраас гаргасан хуваарийн дагуу тогтоол шийдвэр, бодлогын бичиг баримтын биелэлтийг тайлан мэдээний хугацаанд тогтмол тайлагнаж хэвшсэн. Хариуцсан ажлын чиглэлээр тохижилт бүтээн байгуулалтын ажлын зурган сан, ногоон байгууламжийн тооллого мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.01<br>2025.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэрэгжүүлж ажилласан байна.<br>- Салбарын тоон мэдээлэл, судалгааг цаг тухай бүр шинэчлэн удирдлагыг салбарын мэдээллээр хангаж ажиллана. | | | |
| 3.2 | Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч бүртгэх, уламжлах, шуурхай шийдвэрлэх | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тоо хэмжээ | - | -Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна<br>-Хуулийн хугацаанд ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж, мэдээ тайланг холбогдох байгууллагад тайлагнасан байна | Өөрийн ажлын чиглэлээр өргөдөл гомдол, иргэдээс ирүүлээгүй болно.<br><br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.01<br>2025.12 | 100 |
| 3.3 | Холбогдох үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргаж, нэгтгүүлэх | Хяналтад орсон заалт бүрээр | - | Зорилт тус бүрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангаж ажилласан | Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр, Тэрбум мод үндэсний хөтөлбөрүүдийн тайланг жилийн эцсийн төлөвлөгөө, биелэлтийг холбогдох маягтын дагуу тайлагнасан.<br><br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.04<br>-<br>2025.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | | | |
| ДӨРӨВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 4.1 | Хувь хүний хөгжил чадварыг дээшлүүлэх болон төрийн албаны цахим сургалтад хамрагдах. Мөн албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөгө болгон өөрийн ажилд ашиглаж дадал хэвшил болгох . | Хууль эрхзүйн мэдлэг болон албан хэрэг хөтлөх чадвар дээшилсэн байна. | | Хувь хүний хөгжил чадварыг дээшлүүлэх болон төрийн албаны цахим сургалтад хамрагдах. Мөн албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөгө болгон өөрийн ажилд ашиглаж дадал хэвшил болгох . | -Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдсан,<br>-Төрийн албан хаагчдын цахим сургалтад хамрагдсан.<br>-"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сургагч багш бэлтгэх онол практикийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | 2025.01<br>2025.11 | 100 |
| 4.2 | Canva, photoshop программыг бүрэн эзэмшиж, ажлын хэрэгцээнд ажиллаж сурах. | Тус программ дээр ажиллаж сурсан байна. | | Canva, photoshop программыг бүрэн эзэмшиж, ажлын хэрэгцээнд ажиллаж сурах. | Мод бутны тандалт тайралт болон усалгаа арчилгааны талаар мөн мод тарих гарын авлага брошюрыг хийж цахимаар болон багийн иргэдийн нийтийн хурлын үеэр иргэдэд тараан ажилласан. Мөн өөрийн ажлын чиглэлээр цахим постер,мэдээлэл оруулан цахим орчинд сурталчлан ажиллаж байна.<br>Тодорхой үр дүнд хүрсэн -70 хувь | 2025.01<br>2025.11 | 70 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

| | | |
|---|---|---|
| Ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн | З.Оюунсүрэн ( ......[signature]...... ) | 2025.11.27 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

АРВАЙХЭЭР СУМЫН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ
НОГООН БАЙГУУЛАМЖ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ЗАЯАДАВАА ОВОГТОЙ ОЮУНСҮРЭНГИЙН
2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Арвайхээр сумын ЗДТГ
Нэгжийн нэр: Хотын захирагчийн алба

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт : НЭГ. Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт ногоон байгууламжийг нэмэгдүүлж, усалгаа арчилгааг тогтмолжуулан, хотын өнгө үзэмжийг сайжруулах; хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын 2 дахь долоо хоногийн Бямба гарагийг “Мод тарих үндэсний өдөр” болгон зарласантай холбогдуулан нийтээр мод тарих ажлыг өрнүүлэх. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд жилийн ажлын төлөвлөгөөг гаргаж, тарих талбайн байршил, зураглалыг газар зохион байгуулалтын урьд оны төлөвлөгөөнд тусган батлуулах | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Өлзийтийн 4 дүгээр багт 4га талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хамгаалалтын зурвас байгуулж мод бут тарих. | 60 | 10 | 70. | 70 |
| 4. | Дайргын голд ойн урвас байгуулах. | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Согоотын 1 дүгээр багийг жишиг ногоон байгууламжтай баг болгох. | 60 | 10 | 70 | 70 |
| 6. | Их монгол, Баяннамсрай зэрэг цэцэрлэгт хүрээлэнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | 60 | 10 | 70 | 70 |
| 7. | “Арвайн хүрээ” цэцэрлэгт хүрээлэнд мод бут ажлыг зохион байгуулах. | 60 | 10 | 70 | 70 |
| 8. | Байгууллага бүр албан хаагчдынхаа тоогоор мод тарья” аян өрнүүлэх, гадна талбайдаа мод бут тарих боломжгүй байгууллага аж ахуй нэгжээс “Ногоон байгууламжийн журам”-ын дагуу санхүүжилт төвлөрүүлэх. | 60 | 10 | 70 | 70 |
| 9. | Нийтийн эзэмшлийн зам талбайд мод бут, зүлэг, цэцэг тарих ажлыг зохион | 60 | 10 | 70 | 70. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байгуулах | | | | |
| 10. | Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн мод үржүүлгийн газруудын үйл ажиллагааг бодлогоор дэмжин ажиллах | 60 | 10 | 70 | 70 |
| **Зорилт: ХОЁР. "Аж ахуй нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, ногоон өрх, ногоон гудамж бий болгон, сургалт мэдээллийн ажлыг тогтмолжуулах"; хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | "Айл бүр ам бүлийнхээ тоогоор мод тарья" аян өрнүүлэх, хашаандаа тарих боломжгүй айл өрхөөс "Ногоон байгууламжийн журам"-ын дагуу санхүүжилт төвлөрүүлэх | 40 | 10 | 50 | 50 |
| 2. | Байгууллага аж ахуй нэгжүүдийн тохижилт ногоон байгууламжийн ажлын явцад хяналт тавьж, гэрээ байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол ханган ажиллах | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Хэсгийн ахлагч нарыг чадавхижуулах, цуврал сургалтуудыг зохион байгуулах, цахим орчинд мэдээлэл нийтлэн иргэдийн мод тарих оролцоог нэмэгдүүлж ажиллах. | 40 | 10 | 80 | 50. |
| 4. | Өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгох экокурс аялал зохион байнуулах. | 60 | 10 | 70 | 60. |
| **Зорилт: ГУРАВ. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх "; хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч бүртгэх, уламжлах, шуурхай шийдвэрлэх | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Холбогдох үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, биелэлтийг хагас болон бүтэн жилээр гаргаж, нэгтгүүлэх | 60 | 10 | 70 | 70. |
| | **Дундаж оноо:** | | | 70 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Хувь хүний хөгжил чадварыг дээшлүүлэх болон төрийн албаны цахим сургалтад хамрагдах. Мөн албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөгө болгон өөрийн ажилд ашиглаж дадал хэвшил болгох . | 60 | 10 | 70 |
| 2 | Canva, photoshop программыг бүрэн эзэмшиж, ажлын хэрэгцээнд ажиллаж сурах. | 50 | 5 | 55 |
| | **Дундаж оноо** | 50% | 15. | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7. |

| | | | |
|---|---|---|---|
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | 7 | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | 7 | |
| **Дундаж оноо** | | 7 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 7,82 |
| 3. | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо** | | 7,94 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 65,5 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 7 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | 7 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7,94 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | 87,44 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

***Үнэлгээ өгсөн:*** Ерөнхий мэргэжилтэн ...... /..................../

***Нэгжийн дарга*** Б. [signature] ..........

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.15 ..........

*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** З. [signature] ........ /..................../

***Төрийн жинхэнэ албан хаагч:*** З. Оюунсурэн

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.......................

*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

...................................... ............................... /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.05

.......................

*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

...................................... ............................... /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

.......................

*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** **Төсвийн шууд захирагч**

...................................... ............................... /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр* ....................... *(огноо)*